



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/959

Мандалговь

Камержуулах ажлыг зохион байгуулах  
тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 74 дүгээр зүйлийн 74.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.4, 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.1.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг шуурхай илрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж /иргэн/, байгууллагууд гадна болон дотор орчинд хяналтын MNS6423:2019 стандартын шаардлага хангасан камерыг байрлуулах, /гадна камерыг нийтийн эзэмшлийн зам талбайг 50 метр хүртэл хянах боломжтой байрлуулах/ ажлыг зохион байгуулахыг аж ахуйн нэгж /иргэн/, байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

2. Камержуулах ажлыг 9 дүгээр сарын 01-ний дотор зохион байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад заавар зөвлөмж өгч хамтран ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Стандартчилал хэмжил зүйн хэлтэс (А.Пүрэвсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100688